



ДУНДГОВЬ АЙМАГ  
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 18 өдөр

Дугаар 1129

Мандалговь

ГӨндөржүүлсэн бэлэн байдлын үед хэрэгжүүлэх  
арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай

- хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5.в, 29.1.6.б, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, аймгийн засаг даргын 2020 оны А/44 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулахаар гарсан холбогдох шийдвэрүүдийг хэрэгжүүлж, өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд дараах арга хэмжээг зохион байгуулсугай.

Үүнд: а.Тус сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа нийтийн хоолны болон худалдаа үйлчилгээний газруудыг 21 цаг хүртэл ажиллуулах

б.Хариуцлагатай эргүүлийг хуваарийн дагуу хариуцлагатай ажиллуулах

в. Халдварт өвчний сэжигтэй тохиолдол илэрсэн тохиолдолд тусгаарлах байрны бэлэн байдлыг хангах

г.Сумын Эрүүл мэндийн төвийн бэлэн байдлыг хангах, шаардлагатай нөөцийг бүрдүүлэх

2.Улсын хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан амны хаалтыг тогтмол зүүх, хүүхдийг олон нийтийн газраар явуулахгүй байх, тэдэнд тавих анхаарал хяналтаа сайжруулахыг нийт эцэг, эхчүүд, иргэдэд үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (О.Баярсайхан), мэргэжилтэн (О.Уранзаяа), (Б.Саранзаяа), Цагдаагийн төлөөлөгч (Б.Билгүүн) сумын эрүүл мэндийн дарга (Б.Нанжид), сургуулийн захирлуудад даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Р.МОНХТОГОТОХ